

# SikaProof® Membrane

## Дан бүрэлдэхүүнт ус тусгаарлагч шингэн мембран

### Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaProof® Membrane нь усан суурьтай дан бүрэлдэхүүнт уян полимераар баяжуулсан хар тосон акрил эмульс бүхий шингэн ус тусгаарлагч мембран юм.

### Хэрэглээ:

- Бетон болон чулуун ба тоосгон өрлөгийн гадаргуунд хэрэглэх дооод түвшний ус тусгаарлагч
- Барилгын суурь
- Бетонон дээврийн ус тусгаарлагч
- Газар доорх туннелийн дээврийн бетон
- Зоорь, ус зайлуулах суваг

### Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Дан бүрэлдэхүүнт хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн
- Шүршиж, өнхрүүшдэж, багсдаж түрхэх боломжтой
- Элэгдэлд тэсвэртэй, түргэн бэхжих уян бүрээс үүснэ
- Барьцалдан наалдах болон сунах чадвар маш сайн
- Шинэ болон хуучин барилгын аль алинд ч хэрэглэхэд зориулагдсан
- Шингэлэгч агуулаагүй
- Бага зэргийн чийгтэй бетон дээр түрхэх боломжтой

### Зарцуулалт

- 1,2 кг /м<sup>2</sup>  
Бүтээцийн төрлөөс шалтгаалан бодит зарцуулалт тодорхойлогдоно. Ерөнхийдөө 3-4 үе давхарлаж түрхэх шаардлагатай.

### Хэрэглэх заавар

#### Гадаргууг бэлдэх

Гадаргуу бат бэх байж, хуурай, тос тосоол, бетон арчилгааны бодисууд, будаг түрхлэгүүд болон бусад бохирдол болон сул хэсгүүдээс бүрэн ангид байх хэрэгтэй.

## Суурь түрхлэг

Бүтээгдэхүүний түрхэхээс өмнө гадаргуу дээр SikaProof® Membrane-ийг устай хольж (1 : 2 буюу SikaProof® Membrane : Ус) 0,2 л/м<sup>2</sup> (цэвэр SikaProof® Membrane-ийн хэмжээ) хэмжээтэйгээр түрхэж хатаана.

## Хэрэглээ

### **Бетонон дээрийг үс тусгаарлах систем:**

1. Хатаж бэхжсэн суурь түрхлэг дээр SikaProof® Membrane-ий 1-р үеийг 0,4 л/м<sup>2</sup> хэмжээтэйгээр багс, өнхрүүш, шүршигч ашиглан жигд түрхэж хатаана.
2. 1-р үетэй ижил хэмжээтэй SikaProof® Membrane-ийг 2 дахь үед түрхэнэ.
3. SikaProof® Membrane-ы 2-р үеийг чийгтэй байхад нь дээрээс нь SikaLastic® Fleece-120-г тавих.
4. SikaProof® Membrane-ы 3-р үеийг 0,6 л/м<sup>2</sup> хэмжээтэйгээр түрхээд хатаана.
5. SikaProof® Membrane-ы 3-р үеийг хатаж бэхжсэний дараа сүүлийн үе давхар буюу 4-р үеийг 0,4 л/кг<sup>2</sup> хэмжээтэй түрхээд хатаана.

### **Ус тусгаарлах ердийн систем:**

Бүтээгдэхүүний суурь түрхлэг болох SikaProof® Membrane-ийг устай хольж (1 : 2 буюу SikaProof® Membrane : Ус) 0,2 л/м<sup>2</sup> (цэвэр SikaProof® Membrane-ийн хэмжээ) хэмжээтэйгээр түрхэнэ.

SikaProof® Membrane-ийг үе давхар бүрт 0,4 л/м<sup>2</sup> хэмжээтэйгээр 3 давхар түрхэнэ. Үе давхар хооронд SikaProof® Membrane-ийг хатаан бэхжүүлэх хэрэгтэй.

### **Барилгын чигжээс болон хагарал бүхий гадаргуун засварт:**

- SikaProof® Membrane-ийг хэрэглэхээс өмнө бетоны гадаргуу дээрх хагарал ан цавыг болон бетоны зай завсрыг Igas Black чигжээс бүтээгдэхүүн ашиглан засахыг зөвлөж байна.
- Мөн SikaLastic® Fleece-120 хэрэглэхийг зөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг манай Техникийн Хэлтэстэй холбогдож авч болно.

### **Ус тусгаарлагч системийн хамгаалалт**

- SikaProof® Membrane түрхсэн талбайг барилгын ажлын үед тулгарч болох элдэв механик гэмтэлээс хамгаалах элс цемент бүхий шавар зуурмагыг дээрээс нь түрхэж (30 мм-ийн зузаантай) өгөх хэрэгтэй.

## Техникийн мэдээлэл

**Өнгө** Хар (хатаж бэхжсэний дараа)

**Нягт (+20°C орчинд)** ~ 1,0 кг/л

**Хатах хугацаа** 1 – 2 цаг

**Хадгалалт** +5°C+30°C орчинд сав баглааг онгойлгоогүй, бүрэн бүтэн байгаа тохиолдолд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 12 сар хадгалах боломжтой. Хөлдөх болон халах орчинд хадгалахаас сэргийл.

<b>Сав баглаа боодол</b>	20 кг хуванцар сав
<b>Хагарлыг битүүмжлэх шинж чанар</b>	Хялгасан хагарал (хүчитгээгүй)
<b>Эрүүл мэнд, Аюулгүй Ажиллагааны зөвлөмж</b>	<ul style="list-style-type: none"> <li>SikaProof® Membrane нь ямарч хоргүй бүтээгдэхүүн юм. Нүд рүү орсон тохиолдолд тэр дор нь цэвэр усаар сайтар зайлаад эмчид ханд.</li> </ul>
<b>Хязгаарлалтууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт байгууламжын гадаргууд хэрэглэж болохгүй.</li> <li>Шингэлэгч бодисоор шингэлж болохгүй</li> <li>Гүйцэтгэлийн орчин +5°C+50°C хооронд байна</li> </ul>
<b>Хууль эрх зүйн мэдээлэл</b>	<p>Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.</p>



**Sika (Thailand) Limited**  
 Head Office  
 700/37 Moo 5 Bangpakong Industrial Park II,  
 Km.57 Bangna-Trad Rd., T.Klongtamhru,  
 Bangkok District, Cholburi 20000

Tel: +66 3821 4270-85  
 Fax: +66 3821 4286  
 E-mail: sikathai@th.sika.com  
 website: http://www.sika.co.th